



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatkhural@parliament.mn
<http://www.parliament.mn>

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙД Т.АУБАКИР ТАНАА

2025.10.29 № 48

Урьдчилан сэргийлэх арга
хэмжээний асуудлаар

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2- т "Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төлбөр нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн тухайн жилийн шимтгэлийн орлогын 2 хувиас багагүй байна" гэж заасны дагуу 6,468.5 сая төгрөгөөс багагүй хэмжээний зардал урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулахаар байна. Гэтэл 2026 оны Төсвийн тухай хуулийн төсөлд 3,269.6 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн шимтгэл төлөгчдийн эрх ашиг зөрчигдөх нөхцөл байдал бүрдсэн байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. 2023 оноос хойшхи үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зохион байгуулалт, хүрсэн үр дүнгийн талаар;


2. 2023 оноос хойшхи урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсвийн гүйцэтгэл, зарцуулалтын талаар;

3. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасан "Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төлбөр нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн тухайн жилийн шимтгэлийн орлогын 2 хувиас багагүй байна" гэсэн шаардлагыг хэрхэн ханган ажиллаж байгаа талаар.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан хугацаанд бичгээр ирүүлнэ үү.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Б.УЯНГА



2025000079